



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/110/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 51-261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 51-261628 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бодьтусгал- Аудит ХХК-ийн
Захирал: З.Мягмарсүрэн
Утас: 99080074 Цахим хаяг: boditusgal.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
5.1 Шилэн дансны мэдээлэл	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
8. Аудитын илрүүлэлт	11
8.1 Залруулсан алдаа	11
8.2 Зөвлөмж	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/605
танай _____-ны № _____-т

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
М.БАТТУЛГА ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 12,152.2 сая төгрөгийн ТЭЗҮ, судалгааны ажлуудыг гэрээ дүгнэсэн актыг үндэслэн, бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгээгүй байгаа нь санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно. Үүнд:

- Хөгжлийн банкнаас авсан 10,599,014 ам доллар буюу 30,194.5 сая төгрөгийн үндсэн зээл, 4,508,503 ам.долларын буюу 12,843.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөр байгаа, 2021 оны 3 дугаар сарын 31-ээс эхлэн хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд орсон.

- Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	53,353.81	703,349,503.06
1.1.2	Дансны авлага	134,701.96	
1.1.6	Бараа материал	10,252,711.80	10,206,428.48
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,152,301,312.41	14,788,277,040.41
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,162,742,079.97	15,501,832,971.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	158,440,956.96	114,865,416.13
1.2.2	Биет бус хөрөнгө	18,637,281,177.19	18,636,061,935.48
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,795,722,134.15	18,750,927,351.61
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	30,958,464,214.13	34,252,760,323.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,100,061,112.33	104,013,320.20
2.1.1.2	Цалингийн өглөг	305,187,448.26	32,399,502.74
2.1.1.3	Татварын өр	34,120,475.35	3,988,417.84
2.1.1.4	НДШ-ийн өглөг	81,677,378.73	10,705,076.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	61,976,988.38	5,903,589.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,583,023,403.05	157,009,906.28
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	30,201,995,300.33	30,639,693,426.70
2.1.2.5	Урт хугацаат зээлийн хүү	9,456,994,507.49	12,398,598,923.28
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	39,658,989,807.82	43,038,292,349.98
2.2	Өр төлбөрийн нийт дүн	41,242,013,210.87	43,195,302,256.26
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	20,000.00	20,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,635,520,000.00	18,635,520,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(28,919,088,996.74)	(27,578,081,932.70)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(10,283,548,996.74)	(8,942,541,932.70)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	30,958,464,214.13	34,252,760,323.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)		-
4	Түрээсийн орлого		2,347,630.00
8	Бусад орлого		2,198,852,106.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	400,993,327.10	128,847,426.85
11	Санхүүгийн зардал	2,928,361,775.31	2,203,349,223.13
12	Бусад зардал	14,284,452.00	10,082,900.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,590,384,938.81)	31,663,866.64
17	Бусад ашиг (алдагдал)	-	632,011.38
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,934,024,493.22)	-
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,934,024,493.22)	(108,783,935.96)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,934,024,493.22)	(108,783,935.96)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(23,985,064,503.52)	(5,349,524,503.52)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(4,934,024,493.22)	(4,934,024,493.22)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(28,919,088,996.74)	(10,283,548,996.74)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,449,791,000.00	1,449,791,000.00
Залруулсан үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(27,469,297,996.74)	(8,833,757,996.74)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(108,783,935.96)	(108,783,935.96)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	18,635,520,000.00	(27,578,081,932.70)	(8,942,541,932.70)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,257,200.00	2,202,287,100.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,257,200.00	2,202,287,100.00
	Татаас, санхүүжилтийн орлого	1,987,200.00	2,198,655,350.00
	Бусад мөнгөн орлого	3,270,000.00	3,631,750.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,615,271.88	1,500,065,691.48
	Ажиллагчдад төлсөн	-	328,857,619.74
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	89,458,810.29
	Ашиглалтын зардалд төлсөн	497,210.00	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	166,800.00	76,000.00
	Татварын байгууллагад төлсөн	298,788.00	92,236,588.14
	Даатгалын төлбөрт төлсөн		1,984,912.00
	Бусад мөнгөн зарлага	2,652,473.88	987,451,761.31
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,641,928.12	702,221,408.52
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	134,701.96
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	254,000.00	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	254,000.00	134,701.96
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,144,150.00	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,144,150.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	134,701.96
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	940,040.29
	Зээл авсан	-	940,040.29
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	940,040.29
4	Валютын ханшийн зөрүү	-	1.52
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(248,221.88)	703,296,149.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	298,367.14	53,353.81
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,353.81	703,349,503.06

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтын талаар

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 28-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Бодьтусгал-Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юмчмаа, аудитор М.Түвшингэрэл нар гүйцэтгэж, хяналтыг захирал, аудитын менежер З.Мягмарсүрэн хэрэгжүүлсэн.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна гэж үзсэн. Тус компанийн явуулж багаа төсөл нь санхүүжилттэй холбоотой зогсонги байдал үүсэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2020 оны 11 сарын 17-ны 05 тоот тогтоолоор компанийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг 2 байхаар тогтоосонтой холбоотой дотоод хяналт үр нөлөөгүй болсон байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Эрчим хүчний салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэглэдэг, бодлогын баримт бичгийн 1.9-д “харьяа аж ахуйн нэгж байгууллага тус бүр өөрийн үндсэн үйл ажиллагааны онцлог, гадаад, дотоод хүчин хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан тусдаа бодлогын баримт бичигтэй байж болно” гэж заасны дагуу ашиглалтын өмнөх үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт боловсруулаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК -ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 4,934.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 49.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд 2021 оны нийт зардлын дүн 2,342.2 сая төгрөг болж буурсан тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд ерөнхий материаллаг байдлыг нийт зардал 2,342.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 23.4 сая төгрөгөөр тогтоолоо.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн зорилгыг “Эгийн гол усан цахилгаан станц төслийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулснаар Монгол Улсын эрчим хүчний системийн бие даасан байдлыг ханган, аваарын болон нөөцийн хүчин чадлыг бий болгож системийн тогтвортой, аюулгүй ажиллагааг нь дээшлүүлэн, оргил ачааллын горим тохируулгын найдвартай ажиллагааг бүрэн хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг:

- Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бусад техникийн баримт бичгийг боловсруулах;
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн болон бусад судалгааны ажлыг хийж гүйцэтгэх;
- Санхүүгийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцуулах;
- Барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
- Станцын үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн төвийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс 70.0 хувийг Эрчим хүчний яам, 30.0 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийг МУ-ын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 117 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 26 нэгжээр бууруулж, удирдлагын цалин хөлсийг өмнөх жилийн жишгээр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 102 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор “Босго үнэ шинэчлэн батлах” тухай шийдвэр

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	53.4	703,347.5	703,294.1
БХХО	-	-	-
Авлага	134.7	-	134.7
Урьдчилгаа	12,152,301.3	14,788,277.0	-
Бараа материал	10,252.7	10,206.4	(46.3)
Үндсэн хөрөнгө	158,440.9	114,865.4	(43,575.5)
Биет бус хөрөнгө	18,637,281.2	18,636,061.9	(1,219.3)
Нийт хөрөнгийн дүн	30,958,464.2	31,616,722.5	658,258.3
Өр төлбөрийн дүн	41,242,013.2	43,195,282.2	1,953,269.0
Богино хугацаат өглөг	1,583,023.4	157,009.9	(1,426,033.5)
Урт хугацаат өглөг	39,658,989.8	43,038,292.3	3,379,302.5
Эздийн өмч	(10,283,549.0)	(8,942,541.9)	1,341,007.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	30,958,464.2	34,252,760.3	658,258.3

Банк дахь харилцах дансанд 3.1 сая төгрөг, тусгай зориулалттай харилцах дансанд 703.3 сая төгрөг байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2014 оноос эхлэн шилжүүлсэн 12,152.2 сая төгрөгийн ТЭЗҮ, судалгааны ажлуудын үндсэн гэрээний ажлууд бүрэн дуусаагүй, ажлыг хүлээн авсан баримт дутуу гэсэн шалтгаанаар гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна. Үндсэн гэрээний 1 дүгээр үе шат буюу ТЭЗҮ хийлгэх ажил дууссан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 5.6 сая төгрөгийн хангамжийн материал байна. Энэ нь ажилчдын орон тоо буурсан, өөрийн байргүй байгаатай холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрлийн дагуу 58.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бусдад түрээслүүлсэн байна. Ашиглагдахгүй байгаа 7 нэр төрлийн 189.4 сая төгрөгийн 322 ширхэг хөрөнгө байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд байгууллагад өгөх 103.8 сая төгрөг, хувь хүнд өгөх 6.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 10.7 сая төгрөг, хүн амын орлогын албан татварын 4.0 сая төгрөг, 2021 оны 5-12 дугаар сарын 5 ажилтны олгоогүй цалин 32.4 сая төгрөгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2017 онд Эгийн голын усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулах зорилгоор Хөгжлийн банкнаас авсан 10,599,014 ам доллар буюу 30,194.5 сая төгрөгийн үндсэн зээл, 4,508,503 ам.долларын буюу 12,843.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөр байгаа ба тайлант онд төлөлт хийгдээгүй, 2021 оны 3 дугаар сарын 31-ээс эхлэн хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд орсон байна.

Тус шалгагдагч байгууллагын мөрдөж байгаа Эрчим хүчний яамны Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ашиглагдаагүй үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй байх, үндсэн хөрөнгийн өртгийн бүрэлдэхүүнд тухайн хөрөнгийн олж авахад гарсан зардлууд, түүнийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд зардлуудын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг дахин хийх талаар санхүүгийн тайланд зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал / ерөнхий удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардал/, валютын ханшийн зөрүүний олз, гарз, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад ерөнхий удирдлагын зардал 280.2 сая төгрөгөөр буурсан нь орон тоог бууруулсан, санхүүгийн зардал 461.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хугацаандаа төлөгдөхгүй байгаа хүүгийн төлбөрийн торгуулиас шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн удирдлага байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 05 тоот тогтоолоор орон тоог 2 болгож баталсан байна.

Гүйцэтгэлээр Эрчим хүчний сайдын багцаас 2,198.8 сая төгрөг олгогдож, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн түрээсийн орлогоос 2.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, ерөнхий удирдлагын зардалд 128.8 сая төгрөг, санхүүгийн зардалд 2,203.3 сая төгрөг, бусад зардалд 10.1 сая төгрөг зарцуулж, 108.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд хөрөнгө оруулалт, тендерийн худалдан авалт, бусад гэсэн шилэн дансны мэдээлэл оруулдаг бөгөөд Шилэн дансны цахим хуудсанд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн хэсэгт 7 шийдвэр оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөг, түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээлэл оруулах тохиргоо хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яаманд хандаж шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөг, түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээллийг оруулах тохиргоог үүсгүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,634.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж 70.0 хувийн биелэлттэй, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	1,634.2	3	184.4	1	1,449.8	67.5
Нийт дүн	4	1,634.2	3	184.4	1	1,449.8	67.5

Зээлийн хүүгийн зардлыг капиталжуулж бүртгээгүй 1,449.8 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант онд аудитаар капиталжуулж залруулсан.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны захирагчид болон төсвийн асуудал хариуцсан төв байгууллагад анхаарал хандуулах дараах асуудал байна. Үүнд:

Компани Хөгжлийн банкнаас 2017 онд 10,599,014 ам.доллар буюу 30,194.5 сая төгрөгийн зээлийг Засгийн газрын 2013 оны 375 дугаар тогтоолд заасан Эгийн голын усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулахтай холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай авч, ТЭЗҮ, биологийн олон янз байдлын судалгаа хийлгэхэд 14,788.3 сая төгрөг, 469.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх, бусад бараа үйлчилгээний худалдан авалт, цалин, шимтгэл, бусад холбогдох зардалд 14,937.1 сая төгрөгийг зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтрэлттэй байна. Хөгжлийн банкнаас авсан зээл төлөгдөхгүй байгаа нь ЮНЕСКО-ийн Дэлхийн Өвийн Хорооноос гаргасан нэмэлт судалгааны ажил буюу Байгаль нуурт нөлөөлөх биологийн олон янз байдлын судалгааны үр дүн эцэслэгдээгүй, хүлээлттэй, үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаатай холбоотой байна. Энэ нь тус компанийн үйл ажиллагаа, санхүүжилтэд нөлөөлж зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр нь хугацаандаа төлөгдөхгүй хуримтлагдаж, нэмэлт алданги тооцогдох үр дагавартай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,790.2 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 2,636.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчлийг залруулж, 12,154.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 12,154.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон 23.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өмнөх оны 1,449.8 сая төгрөг, тайлант оны 1,186.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн төлбөрийг зардалд тусгасныг тус тус капиталжуулж, залрууллаа.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урьдчилж төлсөн тооцооны данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 12,152.2 сая төгрөгийн ТЭЗҮ, судалгааны ажлуудыг гэрээ дүгнэсэн актыг үндэслэн, бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгээгүй, бусад (гадны зөвлөх)-аар гүйцэтгүүлсэн 6,441,378.35 еврогийн, одоогийн ханшаар 20,748.8 сая төгрөгийн гэрээний зарим заалтууд нь тодорхойгүй, ажил дүгнэхэд хүндрэлтэй, гэрээ дүгнэсэн актууд нь архивын бичиг баримтад дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна"; 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай бүрэн нийцээгүй, тохиолдсон байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга ба тодруулга эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

1.2 Өгсөн зөвлөмж:

ТЭЗҮ-г эргэлтийн бусад хөрөнгөд шилжүүлэн бүртгэх, цаашид ТЭЗҮ болон судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаар хянуулах, ажлын гүйцэтгэлийг гэрээ дүгнэсэн актад тодорхой бичих, баримтын бүрдлийг бүрэн хангуулах, ажлын тайлан, гүйцэтгэлийн баримт материалыг бүрэн хүлээж авсны дараа төлбөрийн тооцоог гүйцэтгэх, дотоод хяналтыг сайжруулах, архивын журмыг мөрдөх

2. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад 5 байгууллагын 0.5 сая төгрөг, 4 хувь хүний 1.4 сая төгрөг, нийт 1.9 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийн үлдэгдлийг улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах байх

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Ашиглагдахгүй байгаа 7 нэр төрлийн 189.4 сая төгрөгийн 322 ширхэг хөрөнгө, элэгдлээрээ өртгөө нөхсөн 153 нэр төрлийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5 " хэмжигдэхүйц байх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1 " ...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбэхэд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Ашиглалтгүй байгаа болон элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Зээлийн хүүгийн зардлыг капиталжуулж бүртгээгүй 1,449.8 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, алдаа, зөрчил давтан гарсан	Санхүүгийн тайланд залруулга хийх	1	1,449,800.0	1	1,449,800.0	2,							
2	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 12,152.2 сая төгрөгийн ТЭЗҮ, судалгааны ажлуудыг гэрээ дүгнэсэн актыг үндэслэн, бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгээгүй, бусад (гадны зөвлөх)-аар гүйцэтгүүлсэн 6,441,378.35 еврогийн, одоогийн ханшаар 20,748.8 сая төгрөгийн гэрээний зарим заалтууд нь тодорхойгүй, ажил дүгнэхэд хүндрэлтэй, гэрээ дүгнэсэн актууд нь архивын бичиг баримтад дутуу	ТЭЗҮ-г эргэлтийн бусад хөрөнгөнд орлого авах, цаашид бусдаар гүйцэтгүүлэх ажлын гэрээг ажлын хэсэг байгуулж нарийвчлан хийх, ач холбогдол бүхий гэрээг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаар хянуулах, ажлын гүйцэтгэлийг гэрээ дүгнэсэн актанд тодорхой бичих, баримтын бүрдлийг бүрэн хангасан үед төлбөрийн тооцоог хийх, дотоод хяналтыг сайжруулах, архивын журмыг мөрдөх	1	12,152,301.3								1	12,152,301.3	

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Өр төлбөрийн хураангуй дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад 5 байгууллагын 0,5 сая төгрөг, 4хувь хүний 1.4 сая төгрөгийн өглөг тооцоо нийлж баталгаажуулаагүй	Өр төлбөрийн үлдэгдлийг их, бага дүнтэй гэж ялгахгүйгээр хууль, дүрэм журамд заасны дагуу баталгаажуулах, ажил гүйлгээ гарсныг тайлант хугацаа өнгөрсний дараа нотлох баримтыг бүрдүүлэх	1	1,911.2									1	1,911.2
4	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Ашиглагдахгүй байгаа 7 нэр төрлийн 189.4 сая төгрөгийн 322 ширхэг хөрөнгө, элэгдлээрээ өртгөө нөхсөн 153 нэр төрлийн 149.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөггүй тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлээгүй	Үндсэн хөрөнгийн ашиглалт болон элгэдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн үнэ болон ашиглалтын хугацааг хууль дүрэм журамд заасны дагуу, эрх бүхий төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх	1	-									1	-
5	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Тайлант онд орлого үр дүнгийн тайланд тусгасан 4,352.2 сая төгрөгийн зээлийн хүүг зардлаас 1,186.2 сая төгрөгийг капиталжуулж бүртгээгүй	Холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх, санхүүгийн тайланд холбогдох залруулгыг хийх	1	1,186,235.7	11,186,235.7									
ДҮН						5 14,790,248.2	22,636,035.7								3	12,154,212.5
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	ЭГУЦС ТӨХХК	АХГ-2022/110/НА-СТА-ТӨА	Шилэн дансны мэдээлэлд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш мөнгөн гүйлгээг оруулах тохируулга хийгдээгүй	Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлэх	1	-									1	-
ДҮН					1	-										-
НИЙТ ДҮН					6	14,790,248.2	2	2,636,035.7							4	12,154,212.5

